

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Error! Bookmark not defined.
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ ...	Error! Bookmark not defined.
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Error! Bookmark not defined.
3.6. Химийн бодисын эрсдлийн менежментийн	Error! Bookmark not defined.
3.7. Хог, хаягдлын менежмент	Error! Bookmark not defined.
3.8. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежмент.....	Error! Bookmark not defined.
3.9. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр .	Error! Bookmark not defined.
3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь ...	Error! Bookmark not defined.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Дожир” хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах	
Төсөл	“Ханшашир” ХХК	
хэрэгжүүлэгч:	Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул, 11-р хороо, “Гурван-Оргил ” хотхон 62-01	
	Хэнтий аймгийн Баян-Овоо сумаас баруун зүгт 25 км-т байрлана.	
Төсөл	Талбайн солбицлууд:	
хэрэгжүүлэх	1. 111° 47' 51”	47° 44' 12”
үйлдвэрийн	2. 111° 47' 00”	47° 44' 12”
байршил:	3. 111° 47' 00”	47° 44' 42”
	4. 111° 47' 51”	47° 44' 42”
	Улсын бүртгэлийн гэрчилгээ	
	Улсын бүртгэлийн дугаар:	9019058081
	Улсын регистрийн дугаар:	2618176
	Улсад бүртгүүлсэн:	2007-05-29
	ТЭЗҮ хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт	
Төсөл	Дугаар:	T/19-15-12
хэрэгжүүлэгч	Он сар:	2019-12-11
байгууллагын	ТЭЗҮ хүлээн авсан АМГ-ын даргын тушаал	
хууль эрх зүйн	Дугаар:	T/137
хүчинтэй	Он сар:	2020-08-07
баримтуудын	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	
жагсаалт:	Дугаар:	MV-016819
	Олгосон:	2014-11-25
	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа	
	Он сар:	2041-04-28

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Төслийн товч танилцуулга

I.1 Төслийн зорилго

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Дожир ордын хайлуур жоншны хүдрийг баяжуулах үйлдвэрийг барьж байгуулан эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компани хүртээхэд уг төслийн зорилго оршино.

"Ханшашир" ХХК нь ажлын туршлага боловсон хүчин, техник, технологийн материаллаг бааздаа тулгуурлан Дожирын баяжуулах үйлдвэрийг 4 жилийн хугацаанд ашиглаж, нөхөн сэргээлтийг холбогдох дүрэм, журмын дагуу бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгнө.

I.2 Төсөл боловсруулагчийн талаар товч танилцуулга

Төсөл боловсруулагч "Хатангазар" ХХК нь 2013 онд байгуулагдан уул уурхайн зураг төсөл, геодези, зураг зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тус компанид уул уурхайн салбар, уулын үйлдвэрлэлд олон жил ажиллаж туршлагажсан геологич инженер, ил болон далд уурхайн инженер, баяжуулагч инженер, эрдэс баялгийн эдийн засагч нарын баг ажиллаж байна.

I.3 Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх товч танилцуулга

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ханшашир” ХХК нь Монгол улсын аж ахуйн нэгжийн бүртгэлд гадаад худалдаа, ашигт малтмал ашиглалт чиглэлээр 2011 оны 5 сарын 26-нд бүртгүүлэн Монгол Улсын бүртгэлийн 9019058081 тоот гэрчилгээ авсан гадаадын хөрөнгө оруулалттай компани юм.

I.4 Төслийн байршил

Дожир нэртэй хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт L-49-8 хавтгайд оршдог. Төслийн талбай нь Баян-Овоо сумын төвөөс зүүн зүгт 25 км, Улаанбаатар хотоос баруун хойш 420 км, Хэнтий аймгийн төвөөс зүүн хойш 100 орчим км зайд байдаг.

I.5 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл болон хайгуулын ажлын талаарх товч түүх

“Ханшашир” ХХК-ны нэр дээр Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт зэргэлдээ орших MV-017305, MV-016819 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай хайлуур жоншны орд байна. Баяжуулах боловсруулах үйлдвэр барих төслийн талбай нь MV-016819 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай Дожир нэртэй 98.37 га талбайд байрлана.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Дожир нэртэй MV-016819 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай талбайг ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг АМГТГ-ын Кадастрын хэлтсээс 2011 оны 04 сарын 28 өдөр “Ханшашир” ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

Дожир нэртэй MV-017305 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай талбайг ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг АМГТГ-ын Кадастрын хэлтсээс 2013 оны 04 сарын 23 өдөр “Ханшашир” ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

I.6 Ордын геологийн нөөц

Ханшашир ХХК-ийн гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын тайланг хэлэлцсэн Эрдэс Баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн хуралдааны ХХ-02-01 дугаар дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 2022 оны 04-р сарын 21-ний өдөр Н-33 тоот тушаал гаргаж, Дожир хайлуур жоншны ордын бодитой ба боломжтой (В+С) нөөцийг нийт ордын хэмжээнд 102.26 мян.тн хүдэр, 70.33 мян.тн хайлуур жоншыг улсын нөөцөд хүлээн авсан байна.

Дожирын хайлуур жоншны ордын зүүн-урд хэсгийн хайлуур жоншны ордод 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлаар хайлуур жоншны хүдрийн бодитой (В) нөөцийг 107062.75 тн-оор, 43.38%-ийн агуулгатай хайлуур жоншны нөөцийг 46442.86 тн-оор, хайлуур жоншны хүдрийн боломжтой (С) нөөцийг 270736.77 тн-оор, 45.38%-ийн агуулгатай хайлуур жоншны нөөцийг 122877.43 тн-оор тус тус тооцоолон ЭБМЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн хуралдааны ХХ-04-06 дүгнэлт гарган АМГТГ-ын даргын 2012 оны 02 сарын 20 өдрийн №112 дугаар тушаалаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

I.7. Үйлдвэрийн байршил

Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос зүүн өмнөд зүгт 420 км, аймгийн төвөөс 100 км зайд оршино.



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил


Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн байршилын солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	111° 47' 51"	47° 44' 12"
2	111° 47' 0"	47° 44' 12"
3	111° 47' 0"	47° 44' 42"
4	111° 47' 51"	47° 44' 42"

I.8 Физик-газарзүй ба эдийн засгийн хөгжлийн байдал

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Дожирийн хайлуур жоншны ордын зүүн урд хэсгийн талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт харъяалагддаг ба сумын төвөөс баруун зүгт 25 км орчимд байрладаг. Мужлалын хувьд хангайгаас тал хээрийн бүс рүү шилжих хэсэг дээр байршина.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан



Зураг 2. Талбайн байршлын зураг

Уул зүй. Монгол орны газар зүйн мужлалаар тал хээрийн болон Хангайн бүсийн заагт орших учраас гадаргын хувьд намхавтар, нам дов толгодорхог болон нам уулын рельеф зонхилж байдаг. Гадарга нь тэгш оройтой, налуу, хажуутай жигд үргэлжилсэн маягийн толгодтой. Хүдрийн талбайн хувьд үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 995-1010м байх бөгөөд гадаргын харьцангуй өндөр нь 10-20м байдаг.

Ус зүй. Гадаргуугийн усан сүлжээний хувьд булаг, шанд, хуурай сайруудтай. Түр зуурын урсгал усны нөлөөгөөр үүссэн жалга сайрууд нь гүн биш ховил үүсгэх ба нэг их урт үргэлжилдэггүй. Хуурай сайрууд нь зун болон намрын улиралд усархаг бороо орсны дараа түр хугацааны урсгал устай байх бөгөөд цугларсан ус нь томоохон хөндийнүүдэд шалбааг тойром үүсгэнэ. Энэ нь багавтар хугацаанд тогтоод хур тунадас дахин орж тэжээгдэхгүй бол хатаж ширгэн алга болдог. Ордын орчимд талбайгаас 8км зайтай Хэрлэн гол урсах ба бороотой үед түр зуурын урсгалтай горхи хөндий амууд даган урсдаг.

Уур амьсгал. Ордын нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарна. Ажиглалтаас үзэхэд цаг уурын температур эрс хэлбэлздэг, хур тунадас багавтар, агаар чийгшилт харьцангуй бага хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард -22-32°C, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард 20°+25°C байдаг ба дулааны улирал 9-р сар дуустал үргэлжилдэг. Хур тунадас жилд дунджаар 160-180мм хүрнэ. Энд баруун хойноосоо чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3м/сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилах болсон.

Хөрсний байдал. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн хөрс зонхилох ба голдуу

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

элсэнцэр, шавранцар агуулна. Хужирлаг цайвар шаргал хөрс нь эх газрын нуурын гаралтай шавранцараас тогтоно. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь 0.15-0.2м хааяа 0.3-0.4м хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, шарилж, божмог гэх мэт. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн байдаг.

Амьтан ургамлын аймаг. Амьтан ургамлын аймаг болон уур амьсгалын хувьд говь, тал хээрийн аль алиных нь шинжийг агуулсан холимог байдалтай. Ургамлын аймаг харьцангуй сийрэг тачирхан ургасан өвстэй бөгөөд илчлэг, тэжээллэг чанартай байдаг. Энд таана, хөмүүл, ерхөг зэрэг ургамал ургах бөгөөд бороо хур элбэгтэй цаг агаарын тааламжтай нөхцөлтэй үед ургамал харьцангуй сайн өтгөн ургадаг.

Ан амьтны хувьд харьцангуй төрөл зүйлийн хувьд багавтар байдаг. Энд тарвага, зурам, оготно, цагаан зээр, үнэг, хярс, туулай, чоно байхаас гадна жигүүртэн шувуудаас сар, тас, элээ хааяа талын бүргэд байна. Жижиг хорхой шавьж харьцангуй элбэг.

Хүн ам, эдийн засаг дэд бүтэц. Талбайн хувьд зөвхөн шороон замаар бусад суурин газруудтай холбогдох бөгөөд хамгийн ойр Баян-Овоо сум хүртэл 25км, Бэрхийн уурхай хүртэл 55км, аймгийн төв хүртэл 100км байна. Хөрсний зам нь харьцангуй эвдрэл багатай бөгөөд зөвхөн хүчтэй борооны дараа эвдрэх эсвэл өвөл цасан шуурганаар зам хаагддаг. Хүн ихэнхийг буриад, халхчууд бүрдүүлдэг ба хүн амын нягтрал харьцангуй сийрэг. Өнөөгийн байдлаар эдийн засгийн гол тулгуур нь нүүдлийн мал аж ахуй бөгөөд ганц нэгээр ажиллаж буй хайлуур жонш хувиараа олборлогч байдаг.

УБ хотоос аймгийн төв хүртэл хатуу хучилттай засмал замтай. Чингис хотоос Чойбалсан хүртэл сайжруулсан шороон замаар явна. Хамгийн ойр орших төмөр замын өртөө Дорнод аймгийн төмөр замын өртөө болон Бор-Өндөрийн өртөө болно. Өндөр хүчдэлийн шугам дайрч өнгөрдөг. Тухайн дүүрэгт хүн ам нягтрал нь 1кв.м талбайд 0.5-0.7 хүн ам ноогдож байгаа нь харьцангуй сийрэг болох юм.

Хамгийн ойр хүн ам суурьшсан төв болох Баян-Овоо сум нь 2000 гаруй хүн амтай. Талбайн орчмоор цөөн тооны малчин өрхүүд зундаа нүүдэллэн ирдэг, тэдний өвөлжөө нь холгүй байдаг. Сумын төвд эмнэлэг, шуудан холбоо, дэлгүүр, буудал, халуун ус зэрэг үйлчилгээний газруудтай.

Тус баяжуулах үйлдвэр нь жилд 38.58%-ийн CaF_2 –ын дундаж агуулгатай 50.0 мян.тн хүдэр флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн CaF_2 –ын агуулгатай ФФ-95 маркийн 19241.6 тн баяжмал гарган БНХАУ-ын Эрээн хотод борлуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Тус бүлэгт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр тооцож, мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн.

2.1 Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Хайлуур жонш баяжуулах үйлдвэр байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн агаарын чанарт дараах хэлбэрээр нөлөөлнө:

- Үйлдвэрийн хүдэр жигдрүүлэх явцад
- Хүдэр бутлах үйл ажиллагааны ухааж ачих үед
- Бутлах үйл ажиллагааны үед
- Ногоон байгууламжын бүтээн байгуулалтын үед
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн
- Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс гарах хийн хаягдал
- Хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж, тухай бүрт зайлуулаагүйгээс орчны агаарт эвгүй үнэр тархах

2.2 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслөөс гүний усанд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээнээс харахад нийт нөлөөллийн зэрэг нь дунд зэрэг буюу 60 хувь байна. Үүнд жонш баяжуулалт болон ахуйн хэрэглээнд ус ашиглах бөгөөд энэ хэмжээгээр гүний усны нөөцийг багасгах нөлөөлөл их, баяжуулалт, хаягдлын сангаас ялгарах бохир ус болон унд ахуйн хэрэглээнээс гарах бохир ус хөрсөнд алдагдсанаар нэвчилт үүсэж гүний усыг бохирдуулах, тоног төхөөрөмж болон авто тээврийн хэрэгслээс шатах тослох материал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний ус бохирдох нөлөөллүүдийн зэрэг дунд богино хугацаанд эрчимтэй нөлөөлөл үүсгэхээр байна.

2.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч нь эвдрэл, нөлөөлөлд өртсөн боловч төслийн зүгээс шинээр бүтээн байгуулалтын ажлыг нэмж хийх болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвчид хамгийн ихээр нөлөөлнө. Мөн машин техникийг зохих маршрутын дагуу явуулаагүйгээс олон салаа зам гарч хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөх, ажилчдын эмх замбараагүй байдлаас хөлөөр хөрс үржил шимээ алдах, хүдэр ачиж буулгах талбайг зөв сонгоогүй, хатуу хучилт хийгээгүй, хог хаягдлыг зориулалтын талбайд хаяагүйгээс хөрс бохирдох, үйлдвэрийн болон авто тээврийн хэрэгслийн шатах

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

тослох материал газрын гадаргад алдагдсанаас хөрсөн бүрхэвч бохирдох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэх магадлалтай

2.4 Газрын хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслөөс газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл 61.7 хувь буюу дунд зэрэглэлд байна. Газрын хэвлийд хоосон орон зай үүссэнээр ойр орчны газрын гадаргад хөрсний нурулт, цөмрөлт бий болох зэрэг нөлөөллийн эрчим их байх ба төсөл хэрэгжих үед заавал бий болох гол сөрөг нөлөөлөл болж байна. Газрын хэвлийд үүсэх хоосон орон зайд мал амьтан унах аюултай нөхцөл байдал бий болох, хаягдал чулуулгийн овоолго, баяжуулсан жонш хадгалагдаж байгаа газрын гадарга бохирдол доройтолд орох нөлөөллүүд нь урт хугацаанд эрчим ихтэй байх боловч үүсэх магадлал харьцангуй бага харин газрын хэвлий ландшафтад гарсан өөрчлөлттэй холбоотойгоор экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт орох, амьтдын амьдрах орчин хязгаарлагдах шууд бус нөлөөлөл урт хугацаандаа нөлөөллийн эрчим бага байхаар байна.

2.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслөөс ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөллийн зэрэг нь 65 хувь буюу дунд зэрэг буюу шинээр хаягдлын сан байгуулах хаягдлын сангийн талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг устгах, авто машины хөдөлгөөний улмаас үүсэх тоосжилт, хатуу хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяхгүйн улмаас ургамлан нөмрөгийн үхжилтийг бий болгох, авто тээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагаанаас ургамал ургаж буй газруудыг талхагдалд оруулах нөлөөлөл дунд хугацаанд эрчим ихтэйгээр тухайн орчны хэмжээнд нөлөөлхөөр байна.

2.6 Амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчинг доройтуулах, дуу чимээ, тоосжилт зэргээс амьтад дайжих, идэш тэжээлийн хомсдол бий болох, үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед ухсан нүх, суваг шуудуу зэргийг битүүлэлгүй орхисноос амьтад унаж бэртэх, улмаар үхэж үрэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй юм. Мөн төсөл хэрэгжих талбайн ойр орчмын экосистемийг шүтэн амьдардаг амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл нь уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх хөрс газрын гадаргын эвдрэлээс бий болох амьтдын амьдрах орчны доройтол, орчны ургамлан нөмрөг талхлагдсанаар идэш тэжээлийн хомсдол бий болох, бэлчээр тархац нутаг нь хумигдсанаар амьтдын өсөлт үржлийн явц алдагдах зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.

2.7 Нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, үнэлгээ

Уг төсөл хэрэгжсэнээр улс орон нутгийн төсөвт жил тутам мөнгөн орлого төвлөрүүлэх ба төсөлд нийт 82 хүний ажлын байр бий болно. Нийт ажилчдын 50-аас доошгүй хувийг нутгийн иргэдээс авч ажилуулах бөгөөд энэ нь сум орон нутгийн ажилгүй иргэдийн тоог багасгах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг багасгах зэрэг нийгэм эдийн засгийн хувьд эерэг нөлөөлөл их байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан байна. Иймд дээрх хуулийн шаардлагын дагуу, төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан.

БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөлөө.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/				Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Агаарын чанар									
1	Үйлдвэрлэл, төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгсэл зэргээс агаар орчинд тоосжилт үүсэх	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тодорхой маршрутаар явуулах	Төслийн талбай				300000	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
2		Дуу чимээ бага гаргадаг техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмж сонгох, суурилуулалтын ажлыг сайн хийх	Төслийн талбай				Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2023	
3		Орчны тоосжилт болон салхины хурд дуу чимээг бууруулах зорилгоор мод сөөг тарих	Төслийн талбай				Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	2023	
4		Төслийн хог хаягдлын цэгээс ялгарах үнэр, тоос шороо, утааны бохирдол нь агаар орчинд сөрөг нөлөө үзүүлнэ	Төслийн талбайд байгуулагдах нэгдсэн хогийн цэгийг стандартын дагуу тохижуулах	Төслийн талбайд нэгдсэн 1 хогийн цэг талбайг тусд нь байгуулж, тэнд ангилан ялгалт хийж зайлуулах арга хэмжээг авдаг байх				--*--	
2. Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглан усан	Үйлдвэрт усыг дахин ашиглахдаа технологийн горимыг алдагдуулахгүйгээр ашиглах	Үйлдвэрийн хэрэглээнд ашиглагдах ус				Үйлдвэрт ашиглагдах усны 80%-ийг эргэлтийн усаар ханган ажилласан	2023	Усны тухай хуулийн 28-р зүйл Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй

**Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур
жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

2	орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Зам усалгааг үүрээр газрын хөрсний температур хамгийн бага үед цаг агаарын мэдээнд уялдуулж услах	Төслийн хүрээнд				--*--	2023	байдлын үнэлгээ MNS0900:2018 Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм А-301 тушаал, Байгаль орчны хохирлын үнэлгээ нөхөн төлбөр тооцох аргачлал Усны тухай хууль 22 зүйл 1 заалт
3. Хөрсөн бүрхэвч									
1		Ахуйн хэрэглээнээс гарч байгаа хаягдлыг зориулалтын тагтай саванд хаях	Төслийн талбай				--*--	2023	
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрс эвдрэл, бохирдолд орох	Үйлдвэрээс шинээр байгуулсан хаягдлын сан руу хаягдал зөөвөрлөх замыг засаж, тэмдэгжүүлэх	Нийт тээвэрлэлтийн зам талбай		10ш	10 тэмдэглэгээ 80.0=800.0		2023	
4		Баяжуулах үйлдвэрийн техникийн болон авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний талбайг тос масло хөрсөнд нэвчихээс сэргийлэн шалыг цементлэх	Засварын газар			Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл Үржил шимт хөрс хуулалт хадгалалт

Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

5		Хаягдлын далангийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, тухай бүрт нь засварлаж байх	Хаягдлын далан		500.0	2023	500.0	2023	MNS 5916:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
4. Газрын хэвлий									
1	Үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглах	Төслийн хүрээнд				--*--	2023	Газрын хэвлийн тухай хууль 31-р зүйлийн 1 дэх заалт
2		Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүнд ИТА-д хяналт тавих, хариуцан ажиллах	Төслийн хүрээнд				--*--	2023	Газрын хэвлийн тухай хууль 32-р зүйлийн 8 дахь заалт
5. Ургамлан нөмрөг									
1		Үйлдвэрийн талбайн кемп төсөл хэрэгжиж байгаа боломжит хэсэгт ногоон байгууламж тохижилтын ажил хийх	Үйлдвэрийн ойр орчимд					2023	
2		Түүхий эдийн тээвэрлэлтийн зам талбайг услах, хаягдлын далад тоос дарагч бодис цацах болон усалгаа хийх	Төслийн талбай					2023	
3		Төслийн талбай орчмын ургамлын судалгааг хийж бүртгэлжүүлэх	Төслийн талбай					2023	
6. Амьтны аймаг									

**Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур
жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

1		Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах, ургамлыг олон салаа зам гарган талхлахгүй байх	Төслийн талбай				--*--	2023	
2	Хаягдлын даланд тэжээвэр мал амьтад орох	Тэжээвэр амьтад орохоос сэргийлэн хашаа хаалт хийж бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж ажиллах	Төслийн талбай				--*--	2023	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал						1300.0			

3.2 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1	Тухайн төслийн хүрээнд “Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах шаардлагагүй болно. Төслийн газрын байршлын кадастрын зураг болон хээрийн судалгааны явцад төслийн талбайд ямар нэгэн айл өрх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байхгүй байна.						2021-2024	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал 4.3.5
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал								--*--

3.3 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		

1. Археологийн дурсгал

**Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур
жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

1	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед Археологийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй	Төслийн талбайд өрөмдлөг хийх, хөрс хуулах ашиглалтын бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд илэрсэн дурсгалуудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дурсгалуудыг малтан судлуулж талбайг чөлөөлүүлэх, түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх, газар хөндөх ажилд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Төслийн талбайд илэрсэн археологийн дурсгалууд байхгүй	--*--	--*--	--*--	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31-р зүйл, Соёлын өвийг хамгаалах тухай хууль 27 зүйлийн 8,9,10,11 дэх заалт

2. Палеонтологийн дурсгал

1	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед Палеонтологийн дурсгал гарч ирж болзошгүй	Төслийн хамрах хүрээнд палеонтологийн дурсгал илрээгүй байна.						
	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал							--*--

3.4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Гэнэтийн осол аваар								
	Ажлын байранд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслэлээр бүрэн хангах	Бүх ажилчид			Бүрэн хангаж ажилласан	2023	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
				ХАБЭА-н дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, галын аюулаас хамгаалах, төлөвлөгөөг ажилчдад танилцуулж, ажил	Бүх ажилчид			

**Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур
жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

	эхлэхээс өмнө аюулгүй ажлын зааварчилгаатай танилцуулах		газартай хамтран сургалт зохион байгуулан ажиллав	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас- ерөнхий шаардлага MNS ISO 13688:200
	Ажилчин бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, дохиолол, холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалгах	Бүх ажилчид	--	2023
	Эмнэлгийн анхан шатны тусламжын хайрцагт байх эм, хэрэгсэл материалуудаар хангах	Бүх ажилчид	--	2023
2. Байгалийн гамшигт үзэгдэл				
Хээрийн болон объектын гал түймэр	Хээрийн болон объектийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж сургалт зохион байгуулах, галаас хамгаалсан зурвас татах, болзошгүй аюул осол тохиолдоход гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бэлэн байлгах. Үүнд: Хүрз, Галын дэгээ, Хөрөө, Сүх, Царил, Хувин, Жоотуу, Элстэй сав (хайрцаг), Устай сав (торх), Эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг, Төрөл бүрийн гал унтраагуур, Агаар дахь тэсрэх болон галын аюултай хольцыг саармагжуулах бодис бүхий хэрэгсэл, Бусад (саармагжуулагч бодис, усан сан, ус		500.0	2023 Галын аюулгүй байдлын тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

**Хэнтий аймгийн Баян-овоо сумын нутагт орших “Ханшашир” ХХК-ийн МҮ-016819 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайлуур
жонш баяжуулах үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

	сорох, шахах хөөрөг, галын хоолой, хошуу г.м.)		
Үер усны аюул	Гэнэтийн үер усны аюулаас урьдчилан сэргийлэн үерийн далан хийж суваг шуудуу татах	--	2023
